

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө мян/төг	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилт %
1	1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;	-Баримтжуулсан байх, -Үр дүнг тооцож, тайлагнасан байх, (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо) -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.	I-IV улирал	Цахим хуудсанд байнга байршуулна.	-	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн. Үүнд; -Гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110, нууцыг чандлан хадгална 11 секундын видео, -Товш аппликейшнийг сурталчлах 30 секундын видео, -Авлигын эсрэг үйлдэл бол бүх нийтийн үйлдэл 28 секундын видеог зэрэг 3 төрлийн видеог www.khanuul.mn байгууллагын албан ёсны цахим хуудсанд тус тус байршуулсан. -Авлигатай тэмцэхэд хүн бүрийн оролцоо чухал юм,	100

							Авлигын эсрэг #Нэгдье 30 секундын видеоог байгууллагын албан ёсны Хан-Уул Эко Дүүрэг фейсбүүк хуудсанд тус тус байршуулсан.	
2		1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх; -Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.	II, IV улирал	2 өдөрлөг зохион байгуулна.	-	Хан-Уул дүүргийн хэмжээнд Авлигын эсрэг үйл ажиллагааны өдөрлөгийг 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулахаар удирдамж, төлөвлөгөө боловсруулж Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан. Удирдамжийн дагуу Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон авлигын эсрэг үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд сурталчлах өдөрлөгийг Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон 25	70

							хорооны байранд Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 18 төрлийн 4495 ширхэг ном, гарын авлага, наалтыг хороодоор дамжуулан иргэдэд тараасан бөгөөд Иргэдэд үйлчлэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон 25 хорооны дэлгэцээр Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Товш аппликэйшнийг сурталчилах видео шторкийг сурталчлах, мөн төрийн үйлчилгээ авахаар ирсэн 304 иргэний гар утсанд Товш аппликэйшн суулгаж өгсөн.	
3		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	-Мэдээллийг сар бүр шинэчлэх; -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	I улирал	Мэдээллийн самбарыг шинээр хийнэ.	-	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Шудрага ёс, хөгжил дэвшилд уриатай “Авлигыг мэдээлэх утас 110” самбарыг дүүргийн 25 хороонд байршуулсан бөгөөд Иргэдэд үйлчлэх төв байранд батлагдсан загварын дагуу дээрх самбарыг шинээр хийж байршуулахад шаардагдах үнийн судалгаа хийж удирдлагад танилцуулсан.	70

4		1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.	-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх; -Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; -Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх.	III улирал	2 видео шторк хийж, албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.	-	Хан-Уул дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээлэл хүргэх, мөн дээрх үйл ажиллагааг эрхлэгч Засаг даргын Тамгын газрын холбогдох нэгж, албан тушаалтан эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий видео шторк хийж байгууллагын албан ёсны Хан-Уул Эко Дүүрэг фэйсбүүк хуудас болон 25 хорооны албан ёсны хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчдын оролцоотойгоор Хан-Уул дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд	100
---	--	--	---	------------	--	---	--	-----

							худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээллийг үйл ажиллагаа эрхлэгчдэд хүргэх агуулга бүхий видео шторк хийлгэж олон нийтэд хүргэсэн. Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 4 төрлийн тв шторк, видео график, теле зохиомжийг дүүргийн www.khanuul.mn цахим хуудасны авлигын эсрэг үйл ажиллагааны ил тод буланд байршуулж иргэд, олон нийтэд хүргэсэн.	
5	2.Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах	2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	-Шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	I, III улирал	2-оос доошгүй сургалтад хамруулсан байна.	-	1.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан Хууль зүйн байнгын хорооны “Журам, маягт, жагсаалт шинэчлэн батлах тухай” 2024 оны 5 дугаар тогтоолыг танилцуулах сургалтад Засаг даргын Тамгын газрын эрх бүхий албан тушаалтныг хамруулсан. 2.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан шинээр томилогдсон эрх бүхий албан тушаалтнуудын сургалтад Засаг даргын Тамгын газрын эрх бүхий 20 албан тушаалтныг хамруулсан.	100

						3.Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн мэдлэг олгох сургалтыг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, сургалтад Засаг даргын Тамгын газар болон хорооны 62 албан хаагчийг хамруулсан. 4.НЗДТГ, АТГ болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад байгууллагын удирдах 8 албан тушаалтныг хамруулсан. 5.Авлигын эсрэг олон улсын өдрөөр зохион байгуулагдсан өдөрлөг, арга хэмжээнд 5 албан тушаалтныг хамруулсан. Тайлант хугацаанд нийт 5 удаагийн сургалт, арга хэмжээнд 96 албан хаагчийг хамруулсан.	
--	--	--	--	--	--	---	--

6		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	II, IV улирал	1 видео шторк хийж, албан ёсны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.	-	Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2024 оны А/219 дүгээр захирамжаар “Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл” олгох эрх дүүргийн Засаг даргад шилжсэнтэй холбогдуулан Хан-Уул дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээлэл хүргэх, мөн дээрх үйл ажиллагааг эрхлэгч Засаг даргын Тамгын газрын холбогдох нэгж, албан тушаалтан эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий видео шторк хийж байгууллагын албан ёсны Хан-Уул Эко Дүүрэг фейсбүүк хуудас болон 25 хорооны албан ёсны хуудсаар дамжуулан иргэд,	100
---	--	---	---	---------------	--	---	--	-----

						олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Видео шторкоор дамжуулан Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн албан хаагчид тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дараах мэдээллийг хүргэсэн. Үүнд; -тусгай зөвшөөрөл хүссэн иргэдийн бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт (ярьж байх үед баримт бичгийн жагсаалт бичгээр гарна), -баримт бичгийг бүрдүүлэхэд шаардлагатай зөвлөмж, -баримт бичгийг шалгах, хүлээн авах (ярьж байх үед процессын дараалал бичгээр гарна), -тусгай зөвшөөрөл олгох хугацаа (ярьж байх үед тогтсон хугацаа бичгээр гарна), -тусгай зөвшөөрөл хүссэн иргэдэд шийдвэрлэлтийг талаарх хариу хүргүүлэх байдал,	
--	--	--	--	--	--	--	--

							-дээрх үйл явцтай холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх суваг, боломжийг Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга танилцуулах (ярьж байх үед гомдол хүлээн авах сувгийн мэдээлэл бичгээр гарна)	
7	3.Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх; -Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх; -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах; -Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	II, III, IV улирал	Гэрээнд холбогдох заалтыг тусгасан байна.	-	Засаг даргын Тамгын газар болон хувийн хэвшлийн хооронд байгуулах бүх төрлийн гэрээний загварыг шинэчилсэн бөгөөд гэрээний “Бусад зүйл” хэсэгт “Авлигаас ангид байх, авлигыг мэдээлэх үүргийг тусган хэрэгжүүлэх” заалтыг тусгасан.	100

8		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх; -Сургалт, мэдээлэл авсан байх; -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.	III улирал	Журмын хэрэгжилтийг хангуулна.	-	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд Авлигатай тэмцэх газартай хамтран Хан-Уул дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдийг нээлттэй сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн.	-
9	4.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	-Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	I-IV улирал	Урьдчилан сэргийлэх 1 удаагийн арга хэмжээ зохион байгуулна.	6.0 сая төгрөг	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирэх гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчил гаргах эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор Засаг даргын Тамгын газар болон хорооны төрийн албан хаагчдын өдөр тутмын ажлын хэрэгцээнд зориулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын	100

							зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн холбогдох заалт бүхий 400 дэвтэр хэвлүүлж, нийт албан хаагчиддаа тараасан.	
10		4.2.Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;	-2-оос доошгүйг зохион байгуулсан байх; -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх	II, IV улирал	2-оос доошгүй үйл ажиллагаа зохион байгуулна.	-	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Morning QUIZ арга хэмжээг зохион байгуулж ЗДТГ-ын 70 албан хаагчийг хамруулсан. QUIZ асуултанд дээрх хуулиуд болон хөгжөөнт, танин мэдэхүйн асуултуудаас бүрдсэн бөгөөд эхний 3 байр тус бүр 1 албан хаагч шалгаруулж, мөнгөн шагнал олгосон.	-

11	5.Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	5.1.Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1 дүгээр улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх; -Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	II, IV улирал	Төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн байна.	-	Байгууллагын албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, байгууллагын ил тод байдлыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр 2024 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Шудрага байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар тус тус батлуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 14 арга хэмжээ, “Шудрага байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн. Дээрх 2 төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн	100
----	--	---	---	---------------	--	---	---	-----

							тайланд тусган байгууллагын албан ёсны хуудсанд байршуулсан. Мөн авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээлэгчийг удирдлагын зүгээс хамгаалах, дарамт шахалт үзүүлэхгүй гэдгээ Засаг даргын Тамгын газрын дарга нийт албан хаагчдад илэрхийлсэн. Байгууллагын “Шудрага байдлын үнэлгээ”-г тогтоох судалгаанд Нэг цэгийн үйлчилгээний төвөөс үйлчилгээ авч бус 150 иргэн, удирдан 15 албан тушаалтан болон гүйцэтгэх 30 албан тушаалтныг хамруулж, судалгааны асуулгыг холбогдох байгууллагад цаасаар хүргүүлсэн.	
12		5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	I улирал	Холбогдох байгууллагын саналыг тусган төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн байна.	-	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар н.Янжинлхам болон Засаг даргын Тамгын газрын дарга С.Энхбаяр, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга З.Буянт нартай биечилсэн уулзалт зохион байгуулж, байгууллагын 2023 оны авлигын эсрэг үйл	100

							ажиллагааны хэрэгжилт, анхаарах асуудал болон 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний талаар санал солилцож, зөвлөмж авсан. Дээрх уулзалтын үеэр Авлигатай тэмцэх газраас 3 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 13 арга хэмжээний санал ирүүлснийг Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 100 хувь тусган батлуулсан бөгөөд байгууллагын “Шудрага байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх 11 арга хэмжээний санал ирүүлснийг мөн 100 хувь тусган батлуулсан.	
13		5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; -khutulbur.iaac.mn цахим санд нэмж оруулсан байх,	I-IV улирал	Батлагдсан төлөвлөгөөг албан ёсны цахим хуудаст байршуулсан байна.	-	Байгууллагын албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, байгууллагын ил тод байдлыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр 2024 онд зохион	100

			-Тайлагнасан байх.				байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Шудрага байдлын үнэлгээ”-г 2024 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын Тамгын газрын даргаар тус тус батлуулж, www.khutulbur.iaac.mn цахим санд товлосон хугацаанд байршуулсан. Дээрх 2 төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулсан.	
14		5.4.Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг нягтлан шалгах ажил зохион байгуулна.	-Нягтлан шалгах ажил зохион байгуулж, үр дүнг танилцуулсан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	II улирал	Захирамжлалын болон гэрээний эрх зүйн үндэслэлд нягтлан шалгалт хийнэ.	-	Тайлант хугацаанд нийт 577 захирамж, 183 тушаал болон 361 гэрээний хууль, эрх зүйн үндэслэлд нягтлан шалгалт хийж, холбогдох арга зүйн зөвлөгөөг өгсөн.	100

ТАЙЛАГНАСАН:
ХҮНИЙН НӨӨЦ, ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.САРАНЦАЦРАЛ 2024 оны дүгээр сарын